



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/2046/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 7033-3019
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2025.02.14 № 05
танай _____-ны № _____-т

Г ХАЙРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.МӨНГӨН-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгагдсан 23,191.0 мянган төгрөгийн 95 толгой малын үлдэгдэл нь малын А дансаар баталгаажуулаагүй, үүний 59 толгой малыг 2024 оны 12 дугаар сард худалдан авсан бөгөөд нас, зүсээр хүлээн авсан актгүй,
2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэхгүйгээр улирал дуусаагүй байхад 3,123.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
3. Хайрхан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны Б/21 дүгээр захирамжаар улс төрийн албан хаагчдад сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож 3,591.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1,13.6, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 15 дугаар зүйлийн 15.1,15.1.3 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд Архангай аймгийн Хайрхан сумын түүхт 100 жилийн ой тохиосонтой холбогдуулан 23 нэр төрлийн үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал бусад, орон нутгийн нөөц хөрөнгө, байгаль орчин нөхөн сэргээх, хамгаалах, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, улсын баяр наадам гэсэн 7 арга хэмжээг хэрэгжүүлэх 1,104,440.0 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,019,978.1 мянган төгрөгийг зарцуулж 85,751.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн үлдэгдэл нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Хайрхан сумын ЗДТГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 34 арга хэмжээг 100 хувь, 10 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээг 70 хувь биелүүлж, хэрэгжилтийг сумын Засаг даргаас 96.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,828,462.00	102,217,575.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,828,462.00	102,217,575.00
351	Түүхий эд материал	1,238,500.00	1,238,500.00
3513	Эм боох материал	1,238,500.00	1,238,500.00
354	Хангамжийн материал	37,093,962.00	70,998,075.00
3541	Бичиг хэргийн материал	2,483,875.00	2,432,375.00
3542	Аж ахуйн материал	8,269,879.00	7,777,600.00
3543	Сэлбэг хэрэгсэл	15,108.00	2,300,000.00
3545	Барилгын засварын материал	1,773,100.00	1,400,000.00
3547	Бусад хангамжийн материал	24,552,000.00	57,088,100.00
355	Биологийн хөрөнгө	6,240,000.00	6,790,000.00
356	Мал амьтад	25,256,000.00	23,191,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,672,549,797.13	3,025,591,302.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,672,549,797.13	3,025,591,302.28
392	Биет хөрөнгө	2,655,769,797.13	3,008,811,302.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,259,045,063.34	1,323,040,463.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-110,609,960.32	-147,135,444.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,104,800.00	304,754,115.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,147,622.12	-70,458,723.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,967,249.28	225,350,336.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	-143,541,603.98	-166,426,934.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,620,458.00	77,160,098.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,001,521.14	-51,293,164.49
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	123,783,472.00	123,783,472.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,914,578,559.00	2,078,507,940.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-698,529,096.93	-746,970,855.21
39217	Ном	58,500,000.00	58,500,000.00
393	Биет бус хөрөнгө	16,780,000.00	16,780,000.00
39301	Програм хангамж	5,500,000.00	5,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,500,000.00	-5,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,780,000.00	16,780,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,742,378,259.13	3,127,808,877.28
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,742,378,259.13	3,127,808,877.28
51	Засгийн газрын хувь оролцоо	2,742,378,259.13	3,127,808,877.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,116,428.17	448,116,428.17
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	448,116,428.17	448,116,428.17
51101	Өмч: - төрийн	448,116,428.17	448,116,428.17
512	Хуримтлагдсан үр дүн	1,748,146,377.41	2,133,576,995.56
5121	Өмнөх үеийн үр дүн	1,748,146,377.41	1,748,146,377.41
5122	Тайлант үеийн үр дүн		385,430,618.15
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	546,115,453.55	546,115,453.55
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,742,378,259.13	3,127,808,877.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,363,834,171.20	1,665,317,495.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	732,492,081.20	483,568,576.93
120	Нийтлэг татварын бус орлого	732,492,081.20	483,568,576.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,523,000.00	2,790,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,523,000.00	2,790,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	692,783,081.20	447,628,576.93

Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	36,186,000.00	33,150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,342,090.00	1,181,748,919.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,070,890.00	78,808,919.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,800.00	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,508,090.00	14,536,919.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,216,000.00	49,222,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	609,271,200.00	1,102,940,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	609,271,200.00	1,102,940,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	855,974,112.52	1,279,470,500.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	855,974,112.52	1,279,470,500.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,448,394.47	1,158,059,482.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,892,377.00	532,913,431.00
210101	Үндсэн цалин	352,892,377.00	532,913,431.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,297,961.00	66,734,948.16
210201	Тэтгэврийн даатгал	30,129,781.16	45,381,997.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,545,073.56	5,286,339.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,836,059.41	4,201,985.33
210204	Ажилгүйдлийн даатгал	700,143.12	1,104,000.43
210205	Эрүүл мэндийн даатгал	7,086,903.75	10,760,624.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,028,668.45	97,940,614.09
210301	Гэрэл, цахилгаан	6,996,783.65	9,771,129.09
210302	Түлш, халаалт	86,899,984.80	86,899,985.00
210303	Цэвэр, бохир ус	131,900.00	1,269,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,869,950.00	73,560,493.88
210401	Бичиг хэрэг	3,457,500.00	4,226,400.00
210402	Тээвэр, шатахуун	18,734,950.00	24,848,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,020,200.00	6,758,936.88
210404	Ном, хэвлэл	79,500.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	20,928,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	839,300.00	837,308.00
210408	Бараа материал акталсны зардал	9,738,500.00	15,841,179.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	4,572,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,572,900.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,780,000.00	4,759,600.00
210702	Дотоод албан томилолт	4,780,000.00	4,759,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,047,565.00	20,632,305.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,391,590.00	19,553,039.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	495,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	175,515.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,460.00	89,966.72
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	54,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,331,873.02	356,945,189.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,984,960.00	139,975,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	580,790.50	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	202,766,122.52	216,969,359.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,525,718.05	121,411,018.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,842,180.00	35,638,082.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,374,100.00

Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,463,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,842,180.00	2,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,683,538.05	85,772,936.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,897,538.05	85,751,936.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	786,000.00	21,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	507,860,058.68	385,846,995.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,245,458.58	416,377.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,245,458.58	416,377.61
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-19,245,458.58	-416,377.61
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	488,614,600.10	385,430,618.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	634,865,090.00	1,184,538,919.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,523,000.00	2,790,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,523,000.00	2,790,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,523,000.00	2,790,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,523,000.00	2,790,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,342,090.00	1,181,748,919.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,070,890.00	78,808,919.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,800.00	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,508,090.00	14,536,919.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,216,000.00	49,222,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	609,271,200.00	1,102,940,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	609,271,200.00	1,102,940,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	630,974,590.00	1,061,740,254.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,974,590.00	1,061,740,254.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,448,871.95	940,329,235.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,892,377.00	532,913,411.00
210101	Үндсэн цалин	273,366,773.00	370,419,783.00
210102	Нэмэгдэл	72,204,670.00	162,493,628.00
210104	Урамшуулал	7,320,934.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,297,961.00	66,734,948.16
210201	Тэтгэврийн даатгал	30,129,781.16	45,381,997.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,545,073.56	5,286,339.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,836,059.41	4,201,985.33
210204	Ажилгүйдлийн даатгал	700,143.12	1,104,000.43
210205	Эрүүл мэндийн даатгал	7,086,903.75	10,760,624.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,028,668.45	97,940,614.09
210301	Гэрэл, цахилгаан	6,996,783.65	9,771,129.09
210302	Түлш, халаалт	86,899,984.80	86,899,985.00
210303	Цэвэр, бохир ус	131,900.00	1,269,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,145,550.00	58,327,506.88
210401	Бичиг хэрэг	3,440,500.00	4,835,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,734,950.00	24,848,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,020,200.00	6,758,936.88
210404	Ном, хэвлэл	110,600.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	20,928,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	839,300.00	836,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	7,932,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,932,900.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,780,000.00	4,759,600.00
210702	Дотоод албан томилолт	4,780,000.00	4,759,600.00

Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,287,565.00	20,632,325.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,631,590.00	19,553,039.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	495,220.00
210803	Даатгалын үйлчилгээ	175,515.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,460.00	89,966.72
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	54,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,016,750.50	151,087,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,435,960.00	151,087,930.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	580,790.50	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,525,718.05	121,411,018.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,842,180.00	35,638,082.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,374,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,463,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,842,180.00	2,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,683,538.05	85,772,936.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,897,538.05	85,751,936.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	786,000.00	21,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,890,500.00	122,798,665.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,890,500.00	122,798,665.00
	Дотоод эх үүсвэрээр	3,890,500.00	122,798,665.00
221001	Их засвар	-	46,995,400.00
222001	Тоног төхөөрөмж	-	7,994,340.00
223001	Бусад хөрөнгө	3,890,500.00	67,808,925.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,890,500.00	-122,798,665.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,116,428.17	546,115,453.55	1,748,146,377.41	2,742,378,259.13
2	Тайлант үеийн үр дүн	-	-	385,430,618.15	385,430,618.15
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,116,428.17	546,115,453.55	2,133,576,995.56	3,127,808,877.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,104,440,000.00	1,019,978,063.85	84,461,936.15	92.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,440,000.00	944,988,398.85	84,451,601.15	91.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,145,900.00	909,350,316.85	76,795,583.15	92.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,891,900.00	532,913,411.00	64,978,489.00	89.13
210101	Үндсэн цалин	597,891,900.00	370,419,783.00	227,472,117.00	61.95
210102	Нэмэгдэл	-	162,493,628.00	162,493,628.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,736,500.00	66,734,948.16	8,001,551.84	89.29
210201	Тэтгэврийн даатгал	50,820,900.00	45,381,997.81	5,438,902.19	89.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,978,900.00	5,286,339.62	692,560.38	88.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,783,100.00	4,201,985.33	581,114.67	87.85

Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,800.00	1,104,000.43	91,799.57	92.32
210205	Эрүүл мэндийн даатгал	11,957,800.00	10,760,624.97	1,197,175.03	89.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,000,000.00	97,940,614.09	59,385.91	99.94
210301	Гэрэл, цахилгаан	9,800,000.00	9,771,129.09	28,870.91	99.71
210302	Түлш, халаалт	86,900,000.00	86,899,985.00	15	100
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,269,500.00	30,500.00	97.65
2104	Хангамж, бараа материалын зардал	56,298,300.00	56,277,506.88	20,793.12	99.96
210401	Бичиг хэрэг	4,842,300.00	4,835,900.00	6,400.00	99.87
210402	Тээвэр, шатахуун	22,800,000.00	22,798,670.00	1,330.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,768,000.00	6,758,936.88	9,063.12	99.87
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00	-	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,928,000.00	20,928,000.00	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840,000.00	836,000.00	4,000.00	99.52
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,046,000.00	44,042,900.00	3,100.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,046,000.00	21,042,900.00	3,100.00	99.99
210604	Урсгал засвар	23,000,000.00	23,000,000.00		100
2107	Томилолт, зочны зардал	4,780,000.00	4,759,600.00	20,400.00	99.57
210702	Дотоод албан томилолт	4,780,000.00	4,759,600.00	20,400.00	99.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,721,100.00	9,697,806.72	23,293.28	99.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,636,100.00	8,618,520.00	17,580.00	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	495,220.00	4,780.00	99.04
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	90,000.00		100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	89,966.72	33.28	99.96
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	54,100.00	900	98.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,672,100.00	96,983,530.00	3,688,570.00	96.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,472,100.00	96,983,530.00	3,488,570.00	96.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00		200,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,294,100.00	35,638,082.00	7,656,018.00	82.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,294,100.00	35,638,082.00	7,656,018.00	82.32
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,374,100.00	19,374,100.00	-	100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,120,000.00	13,463,982.00	7,656,018.00	63.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,800,000.00	-	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,000,000.00	74,989,665.00	10,335.00	99.99
	Дотоод эх үүсвэрээр	75,000,000.00	74,989,665.00	10,335.00	99.99
221001	Их засвар	47,000,000.00	46,995,400.00	4,600.00	99.99
222001	Тоног төхөөрөмж	8,000,000.00	7,994,340.00	5,660.00	99.93
223001	Бусад хөрөнгө	20,000,000.00	19,999,925.00	75.00	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,104,440,000.00	1,019,978,063.85	84,461,936.15	92.35
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,102,940,000.00	1,017,188,063.85	85,751,936.15	92.23
132001	Орон нутгийн төсвөөс	1,102,940,000.00	1,017,188,063.85	85,751,936.15	92.23
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	2,790,000.00	-1,290,000.00	186
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	2,790,000.00	-1,290,000.00	186

Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	100
3	Төсвийн байгууллага	1	1	100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	100
6	Удирдах ажилтан	3	3	100
7	Гүйцэтгэх ажилтан	11	11	100
8	Үйлчлэх ажилтан	7	7	100
9	Гэрээт ажилтан	2	2	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,808,919.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,808,919.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,787,919.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,934,519.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,934,519.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,803,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,803,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,000.00
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	21,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	
	Дотоод эх үүсвэрээр	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,808,919.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,808,919.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,536,919.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,222,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 18,500.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Сумын ОНХС-аар хийгдсэн 18,500.0 мянган төгрөгийн өртөгтэй бод малын тарилгын хашааг үндсэн хөрөнгийн орлогод аваагүй байсныг аудитын явцад залруулж, үндсэн хөрөнгөд бүртгүүлээ.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 14.4.2, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 32,152.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч 2,246.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 29,905.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 32,152.2 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 7,731.1 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Хайрхан сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар байгаль орчны улсын байцаагчид 7,326.7 мянган төгрөгийн, хүнс, жижиг дунд үйлдвэр хоршоо хариуцсан мэргэжилтэнд 6,137.3 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан үндэслэлээр тус тус олгосон бөгөөд урамшуулаас хувь хүний орлогын албан татвар 10 хувь болох 1,346.4 мянган төгрөгийг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг хянаж үзэхэд ЗДТГ-т гэрээт сахиулд 2024 оны 6 дугаар сард 900.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2. Албан шаардлага

3.2.1. Хайрхан сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны Б/04 дүгээр захирамж, Хайрхан сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны Б/03 дугаар тушаалаар ЗДТГ-ын 10 албан хаагчийн 2024 оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 3,123.3 мянган төгрөгийг ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэхгүйгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" -ын 2.4-д "Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална", 2.5-д "Энэ журмын 2.4-д зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Малын бүртгэлийг хянаж үзэхэд санхүүгийн тайланд 23,191.0 мянган төгрөгийн 95 толгой малын үлдэгдэл тайлагнасан боловч жилийн эцсийн мал тооллогод хамруулж малын А дансаар баталгаажуулаагүй, үүнээс 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн мал худалдах, худалдан авах гэрээгээр 11,176.0 мянган төгрөгийн 59 толгой хонь худалдан авсан боловч малыг нас, зүсээр хүлээн авсныг нотлох баримтгүй, бодитой оршин байгаа эсэх нь нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2.3. Хайрхан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны Б/21 дүгээр захирамжаар засаг даргын орлогч болон 5 багийн засаг дарга буюу улс төрийн албан хаагчдад сарын үндсэн цалингийн 40 хувийн үр дүнгийн урамшуулалд нийт 3,591.5 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", үүнд 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ОНХС-аар хийгдсэн мал тарилгын хашааг бүртгэлд тусгаагүй	1	18500.0	1	18500.0			1	18500.0				
Нийт дүн	1	18500.0	1	18500.0			1	18500.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	1	900.0	1	900.0								
Улс төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон	1	3591.5			1	3591.5						
Мөнгөн урамшуулаас ХХОАТ-ын 10 хувийг суутгаагүй	1	1346.4	1	1346.4								
Үр дүнгийн урамшууллыг улирал дуусаагүй байхад ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэлгүйгээр олгосон байна.	1	3123.3			1	3123.3						
Малын А дансгүй, мал хүлээн авсан актгүй	1	23191.0			1	23191.0						
Дүн	5	32152.2	2	2246.4	3	29905.8						